

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



1000 хоног тулган кэвлэл
1 онь 10 дугаар сарын 27
№40 /661/

Монгол Улсын
олон улсын гэрээ

1606

Эдийн засаг, нийгэм, соёлын
эрхийн тухай олон улсын
пактын нэмэлт протокол

Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг

1616

Бурхан халдуны тухай

Монгол Улсын
Дээд шүүхийн
тогтоол

1649

Эрүүгийн хуулийн 72 дугаар
зүйлийг шүүхийн практикт
хэрэглэх тухай

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**

- | | | |
|------|--|------|
| 335. | Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол | 1606 |
|------|--|------|

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|----------------------|------------|------|
| 336. | Бурхан халдуны тухай | Дугаар 203 | 1616 |
|------|----------------------|------------|------|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------|------|
| 337. | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 164 | 1617 |
|------|---|------------|------|

- | | | | |
|------|--|------------|------|
| 338. | Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт батлах тухай | Дугаар 173 | 1621 |
|------|--|------------|------|

- | | | | |
|------|---|------------|------|
| 339. | Шинжлэх ухааны салбарыг дэмжих зарим арга хэмжээний тухай | Дугаар 174 | 1623 |
|------|---|------------|------|

- | | | | |
|------|--------------------|------------|------|
| 340. | Журам батлах тухай | Дугаар 177 | 1630 |
|------|--------------------|------------|------|

- | | | | |
|------|--------------------|------------|------|
| 341. | Ой тэмдэглэх тухай | Дугаар 180 | 1644 |
|------|--------------------|------------|------|

- | | | | |
|------|---|------------|------|
| 342. | Зам, тээвэр, барилга, нийтийн аж ахуйн салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай | Дугаар 184 | 1645 |
|------|---|------------|------|

- | | | | |
|------|---|------------|------|
| 343. | Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай | Дугаар 187 | 1646 |
|------|---|------------|------|

- | | | | |
|------|---|------------|------|
| 344. | Түлш, эрчим хүчний салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай | Дугаар 188 | 1647 |
|------|---|------------|------|

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|------|
| 345. | Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай | Дугаар 20 | 1649 |
|------|--|-----------|------|



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТЫН НЭМЭЛТ ПРОТОКОЛ*

Удиртгал

Энэхүү Протоколд оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтний бүлийн бүх гишүүний заяагдмал нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс болохыг анхааралдаа авч,

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүн бүр нэр төр, эрхийн хувьд адил тэгш, эрх чөлөөтэй төрдөг бөгөөд уг тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс, өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан аливаа алагчлалгүйгээр эдлэх эрхтэй хэмээн тунхагласныг тэмдэглэж,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон хүний эрхийн олон улсын Пактуудад хүн бүр иргэний, соёлын, эдийн засаг, улс төр, нийгмийн эрхээ эдлэх нөхцлөөр хангагдсан үед л хүн ардын айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх гэсэн эрхэм дээд эрмэлзэл биелэгдэнэ хэмээн хүлээн зөвшөөрснийг санаж,

Хүний бүх эрх, үндсэн эрх чөлөө нь түгээмэл, хуваагдашгүй, өөр хоорондоо харилцан хамаарал, шүтэлцээ бүхий шинж чанартайг дахин нотолж,

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (цаашид "Пакт" гэх)-д оролцогч улс бүр дангаар болон олон улсын дэмжлэг, хамтын ажиллагаа, тэр дундаа эдийн засаг, техникийн туслалцаатайгаар өөрт буй нөөц бололцооныхоо хүрээнд зохистой бүхий л аргаар, тухайлбал хууль тогтоомж батлан гаргах замаар Пактад заасан эрхийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах үүрэг хүлээснийг санаж,

Пактын зорилго болон түүний заалт бүрийн хэрэгжилтийг хангахын тулд энэхүү Протоколд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо (цаашид "Хороо" гэх)-нд олгох нь зүйтэй гэж үзэж,

**Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 19/640/ дугаарт нийтлэгдсэн.*



Дор дурдсан зүйлийг тохиролцов:

1 дүгээр зүйл

Өргөдөл хүлээн авах, түүнийг хянан хэлэлцэх талаарх Хорооны эрх хэмжээ

1. Пактад оролцогч бөгөөд энэхүү Протоколд оролцогч болж байгаа улс нь уг Протоколд заасны дагуу өргөдөл хүлээн авах, түүнийг хянан хэлэлцэх тухай Хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрнө.

2. Энэхүү Протоколд нэгдэн ороогүй Пактад оролцогч улстай холбогдол бүхий аливаа өргөдлийг Хороо хүлээж авахгүй.

2 дугаар зүйл

Өргөдөл

Өргөдлийг Пактад тусгагдсан эдийн засаг, нийгэм, соёлын аливаа эрхийг тухайн оролцогч улс зөрчсөний улмаас хохирсон хэмээн мэдүүлж буй түүний харьяалалд буй хувь хүн болон бүлэг хүмүүс, эсхүл тэднийг төлөөлөн гаргаж болно. Өргөдлийг хувь хүн буюу бүлэг хүмүүсийн нэрийн өмнөөс гаргах бол ийнхүү өргөдөл гаргагч нь тэднийг зөвшөөрөлгүйгээр төлөөлөх болсноо нотлохоос бусад тохиолдолд тэдний зөвшөөрснөөр уг өргөдлийг гаргана.

3 дугаар зүйл

Өргөдөл хүлээн авах

1. Хороо нь дотоодын эрх зүйн бололцоотой бүх арга хэрэгслийг ашигласан нь тогтоогдоогүй өргөдлийг хянан үзэхгүй. Ийм арга хэрэгслийг ашиглах явдал нь хүндэтгэх шалтгаангүйгээр удааширсан бол энэ журмыг мөрдөхгүй.

2. Дараах тохиолдолд Хороо өргөдлийг хүлээн авахаас татгалзана.

Үүнд:

(a) Өргөдөл гаргагч дурдсан цаг хугацаанд өргөдөл гаргах боломжгүй байснаа нотолсноос бусад тохиолдолд дотоодын эрх зүйн арга хэрэгслийг ашиглаж дуусгаснаас хойш 1 жилийн дотор багтааж өргөдлөө гаргаагүй бол;

(b) Өргөдөлд дурдсан баримт холбогдох оролцогч улсын хувьд энэхүү Протокол хүчин төгөлдөр болохоос өмнө тохиолдсон буюу дурдсан хугацаанаас хойш үргэлжлээгүй бол;

(c) Тухайн асуудлыг өмнө нь Хороо хянан хэлэлцсэн, эсхүл олон улсын хянан шалгах буюу зохицуулах өөр журмын дагуу хянан



хэлэлцсэн буюу хэлэлцэж байгаа бол;

(d) Өргөдөл Пактын заалтуудад нийцэхгүй байвал;

(e) Өргөдөл илтэд үндэслэлгүй, үндэслэл нь хангалтгүй, эсхүл зөвхөн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээлэлд үндэслэсэн байвал;

(f) Өргөдөл гаргах эрхийг урвуулан ашигласан бол;

(g) Эзэн нь тодорхойгүй болон өргөдлийг бичгээр гаргаагүй бол.

4 дүгээр зүйл

Бодитой хохирол учирсныг нотлоогүй өргөдөл

Хороо нь өргөдөлд түгээмэл ач холбогдол бүхий чухал асуудлыг хөндсөн хэмээн үзсэнээс бусад тохиолдолд өргөдөл гаргагчид бодит хохирол учирсныг нотолж чадаагүй өргөдлийг шаардлагатай бол хянан хэлэлцэхээс татгалзаж болно.

5 дугаар зүйл

Түр зуурын арга хэмжээ

1. Хороо өргөдлийг хүлээн авсны дараа болон түүний талаар зарчмын шийдвэр гаргахаасаа өмнөх аль ч үед холбогдох оролцогч улсад хандаж, эрх нь зөрчигдсөн байж болзошгүй хохирогч буюу хохирогчдод барагдашгүй хохирол учруулахгүй байх үүднээс тухайн оролцогч улсаас зайлшгүй шаардлагатай түр зуурын арга хэмжээ авахыг хүсч болно.

2. Хороо энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу олгогдсон эрх мэдлээ хэрэгжүүлэх явдлыг тухайн өргөдлийг хүлээн авах эсэх буюу түүний талаар зарчмын шийдвэр гаргасан гэж үзэхгүй.

6 дугаар зүйл

Өргөдлийг хүргүүлэх

1. Хороо нь холбогдох оролцогч улсад мэдэгдэлгүйгээр өргөдлийг хүлээн авах боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд энэхүү Протоколын дагуу ирүүлсэн аливаа өргөдлийг тухайн оролцогч улсад мэдээллийн нууцлалыг хадгалан хүргүүлнэ.

2. Өргөдлийг хүлээн авсан оролцогч улс уг асуудлыг тодруулсан тайлбар буюу мэдэгдэл, түүнчлэн түүнтэй холбоотой аливаа арга хэмжээ



авсан бол тэр тухай тайлбар, мэдэгдэл бичгээр гаргаж, 6 сарын дотор Хороонд хүргүүлнэ.

7 дугаар зүйл Найрсаг зохицуулалт

1. Хороо энэхүү Пактад тусгагдсан үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр тухайн асуудлыг найрсагаар зохицуулахад нь талуудад дэмжлэг үзүүлнэ.

2. Найрсаг зохицуулалтын үр дүнд хүрсэн тохиролцоогоор энэхүү Протоколын дагуу өргөдөл хянан хэлэлцэх ажиллагаа хаагдана.

8 дугаар зүйл Өргөдлийг хянан үзэх

1. Хороо нь энэхүү Протоколын 2 дугаар зүйлийн дагуу хүлээн авсан өргөдөл болон түүнтэй холбоотойгоор холбогдох талуудад хүргүүлсэн болон Хороонд ирүүлсэн бүх баримтыг хянан үзнэ.

2. Хороо нь хаалттай хуралдаанаар энэхүү Протоколын дагуу өргөдлийг хянан үзнэ.

3. Энэхүү Протоколын дагуу өргөдлийг хянан үзэхдээ Хороо нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүтцийн байгууллагууд, төрөлжсөн байгууллагууд, сангууд, хөтөлбөр болон механизм, түүнчлэн олон улсын бусад байгууллага, түүний дотор хүний эрхийн бүс нутгийн байгууллагуудаас гаргасан баримт бичгүүд, холбогдох оролцогч улсаас ирүүлсэн санал, тайлбар зэрэг холбогдох баримт бичгийг харгалзан үзэж болно.

4. Энэхүү Протоколын дагуу өргөдлийг хянан үзэхдээ Хороо нь Пактын II хэсэгт заасны дагуу оролцогч улсаас авсан арга хэмжээ нь оновчтой эсэхийг авч үзнэ. Ингэхдээ Хороо нь тухайн оролцогч улс Пактад заасан эрхийг хэрэгжүүлэх зорилгоор төрөл бүрийн бодлогын арга хэмжээ авах боломжтойг харгалзана.

9 дүгээр зүйл Хорооны саналын мөрөөр авах арга хэмжээ

1. Хороо өргөдлийг хянан үзсэний дараа түүний талаарх саналаа зөвлөмжийн хамтаар холбогдох талуудад хүргүүлнэ.

2. Оролцогч улс нь Хорооноос ирүүлсэн санал, зөвлөмжийг авч үзэн тэдгээрийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээлэл



болон хариуг Хороонд бичгээр хүргүүлнэ.

3. Хороо нь оролцогч улсаас түүний санал, зөвлөмжийн хариуд авсан арга хэмжээний тухай нэмэлт мэдээлэл ирүүлэх, тухайлбал Хороо шаардлагатай гэж үзвэл Пактын 16 болон 17 дугаар зүйлийн дагуу бэлтгэх дараагийн илтгэлдээ уг мэдээллийг тусгахыг хүсч болно.

10 дугаар зүйл **Улс хоорондын шинжтэй өргөдөл**

1. Нэг оролцогч улсаас нөгөө оролцогч улсыг Пактаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа талаар гаргасан өргөдлийг хүлээн авч хянан хэлэлцэх Хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрч буйгаа энэхүү Протоколд оролцогч улс энэхүү зүйлийн дагуу хэдийд ч мэдэгдэж болно. Хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрч ийнхүү мэдэгдсэн оролцогч улсаас гаргасан өргөдлийг л энэхүү зүйлийн дагуу хүлээн авч, хянан үзэж болно. Ийм мэдэгдэл хийгээгүй оролцогч улсаас ирүүлсэн ямар ч өргөдлийг Хороо хүлээн авахгүй. Энэхүү зүйлийн дагуу хүлээн авсан өргөдлийг дараах журмаар шийдвэрлэнэ. Үүнд:

(a) Энэхүү Протоколд оролцогч улс өөр нэг оролцогч улсыг Пактаар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна гэж үзвэл энэ талаар тухайн оролцогч улсад бичгээр мэдэгдэж болно. Тэрхүү оролцогч улс энэ тухайгаа Хороонд мөн мэдэгдэж болно. Хүлээн авагч улс нь өргөдлийг хүлээн авснаас хойш 3 сарын дотор тухайн асуудлыг тодруулсан тайлбар болон бусад мэдээллийг мэдэгдэл ирүүлсэн улсад бичгээр хүргүүлэх бөгөөд түүндээ энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр бэлтгэж буй эрх зүйн арга хэмжээ, дотоодын журам зэргийн талаар боломжоор нь тусгасан байна.

(b) Хүлээн авагч улс эхний мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 сарын дотор тухайн асуудал холбогдох хоёр оролцогч улсын аль алиных нь хувьд нааштайгаар шийдэгдээгүй бол аль ч улс нь Хороонд болон нөгөө улсдаа мэдэгдэл хүргүүлэх замаар асуудлыг Хороонд уламжлах эрхтэй.

(c) Хороо нь ийнхүү уламжлагдсан асуудлыг дотоодын эрх зүйн бололцоотой бүх арга хэрэгслийг ашигласныг нотолсны дараа л авч үзнэ. Харин ийм арга хэрэгслийг ашиглах явдал нь хүндэтгэх шалтгаангүйгээр удааширсан бол энэ журмыг мөрдөхгүй.

(d) Энэхүү хэсгийн (c) заалтыг хэрэгжүүлэхдээ Хороо нь энэхүү Пактад тусгагдсан үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр тухайн асуудлыг найрсагаар зохицуулахад нь талуудад дэмжлэг үзүүлнэ.



(e) Хороо нь хаалттай хуралдаанаар энэхүү Протоколын дагуу өргөдлийг хянан үзнэ.

(f) Хороо нь энэхүү хэсгийн (b) заалтад дурдсаны дагуу уламжилсан асуудлаар холбогдох мэдээлэл гаргуулах зорилгоор (b) заалтад дурдсан холбогдох оролцогч улсуудад хандаж болно.

(g) Энэхүү хэсгийн (b) заалтад дурдсан холбогдох оролцогч улсууд нь Хороогоор асуудлыг хянан хэлэлцэх үед төлөөлөл илгээх, амаар болон бичгээр мэдээлэл өгөх эрхтэй.

(h) Хороо нь энэхүү хэсгийн (b) заалтын дагуу мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш бүхий л боломждоо тулгуурлан дараах байдлаар илтгэл хүргүүлнэ. Үүнд:

(i) Энэхүү хэсгийн (d) заалтад дурдсаны дагуу шийдэлд хүрсэн бол Хороо илтгэлээ баримт болон хүрсэн шийдлийг тусгасан товч мэдэгдэл байдлаар үйлдэнэ.

(ii) Энэхүү хэсгийн (d) заалтад дурдсаны дагуу шийдэлд хүрээгүй бс л Хороо илтгэлдээ холбогдох оролцогч улсуудын хооронд үүссэн асуудлын талаарх баримт мэдээллийг тусгана. Холбогдох оролцогч улсуудаас бичгээр өгсөн мэдээлэл болон аман мэдэгдлийн тэмдэглэлийг илтгэлд хавсаргана. Мөн түүнчлэн Хороо нь холбогдох оролцогч улсуудын хоорондын асуудалд хамааралтай гэж үзсэн аливаа саналаа зөвхөн тэдгээр оролцогч улсуудад хүргүүлж болно.

Ямар ч нөхцөлд илтгэлийг холбогдох оролцогч улсуудад хүргүүлнэ.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу гаргасан мэдэгдлийг оролцогч улс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулах бөгөөд тэрээр мэдэгдлийн хуулбарыг бусад оролцогч улсуудад хүргүүлнэ. Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх замаар мэдэгдлийг хэдийд ч татан авч болно. Ингэж татан авах нь энэхүү зүйлийн дагуу өмнө хүргүүлсэн өргөдөлд тусгагдсан аливаа асуудлыг хянан хэлэлцэхэд саад болохгүй. Холбогдох оролцогч улс шинээр мэдэгдэл гаргах хүртэл мэдэгдлээ татан авсан тухай Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэнээс хойш энэхүү зүйлийн дагуу тухайн оролцогч улсаас дахин өргөдөл хүлээн авахгүй.



11 дүгээр зүйл Хянан шалгах ажиллагаа

1. Энэхүү Протоколд оролцогч улс нь Хорооны энэхүү зүйлд заасан эрх хэмжээг хүлээн зөвшөөрч буйгаа хэдийд ч мэдэгдэж болно.

2. Пактад заасан эдийн засаг, нийгэм, соёлын аливаа эрхийг оролцогч улс ноцтойгоор буюу удаа дараа зөрчиж байгаа тухай баталгаатай мэдээллийг Хороо хүлээн авсан бол мэдээллийг шалгахад хамтран оролцож, холбогдох мэдээллийн талаар саналаа ирүүлэхийг оролцогч улсаас хүснэ.

3. Холбогдох оролцогч улсаас ирүүлсэн аливаа санал, түүнчлэн тухайн асуудалтай холбоотой бусад найдвартай мэдээллийг харгалзан Хороо хянан шалгах ажиллагаа явуулж, дүнг яаралтай илтгэх зорилгоор нэг буюу хэд хэдэн гишүүнээ томилж болно. Шаардлагатай гэж үзсэн бөгөөд оролцогч улс зөвшөөрсөн тохиолдолд тухайн улсын нутаг дэвсгэрт очиж, хянан шалгах ажиллагаа явуулж болно.

4. Ийм хянан шалгах ажиллагааны нууцлалыг хангах бөгөөд энэхүү ажлын бүхий л үе шатанд оролцогч улстай хамт... ажиллана.

5. Хянан шалгах ажиллагааны дүнг судлан үзсэний дараа Хороо нь уг дүнг аливаа тайлбар, зөвлөмжийн хамтаар холбогдох оролцогч улсад хүргүүлнэ.

6. Холбогдох оролцогч улс хянан шалгах ажиллагааны дүнг хүлээн авснаас хойш 6 сарын дотор Хорооноос ирүүлсэн тайлбар, зөвлөмжийн талаарх саналаа Хороонд ирүүлнэ.

7. Энэхүү зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хянан шалгах ажиллагаа дууссаны дараа холбогдох оролцогч улстай зөвлөлдсөний үндсэн дээр Хороо нь энэхүү Протоколын 15 дугаар зүйлийн дагуу бэлтгэх жилийн илтгэлдээ тухайн ажиллагааны үр дүнгээс тусгах эсэхээ шийдвэрлэж болно.

8. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу мэдэгдэл гаргасан аливаа оролцогч улс нь Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэнээр уг мэдэгдлээ хэдийд ч татан авч болно.

12 дугаар зүйл

Хянан шалгах ажиллагааны мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Энэхүү Протоколын 11 дүгээр зүйлийн дагуу явуулсан хянан шалгах ажиллагааны хариуд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг Пактын 16 болон 17 дугаар зүйлийн дагуу бэлтгэх илтгэлдээ тусгахыг холбогдох оролцогч улсаас Хороо хүсч болно.

2. Хороо нь шаардлагатай тохиолдолд 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан 6 сарын хугацаа дууссаны дараа хянан шалгах ажиллагаатай холбогдуулан авсан арга хэмжээний тухай мэдээлэхийг холбогдох оролцогч улсаас хүсч болно.

13 дугаар зүйл

Хамгаалалтын арга хэмжээ

Энэхүү Протоколын дагуу Хороонд өргөдөл гаргасан өөрийн харьяалалд буй хувь хүнийг зүй бус харьцаа болон айлган сүрдүүлэх явдлаас хамгаалах үүднээс оролцогч улс шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

14 дүгээр зүйл

Олон улсын дэмжлэг ба хамтын ажиллагаа

1. Хороо нь шаардлагатай гэж үзвэл холбогдох оролцогч улсын зөвшөөрөлтэйгээр өргөдлийн талаарх санал, зөвлөмж, хянан шалгах ажиллагааны явцад илрүүлсэн техникийн туслалцаа буюу зөвлөгөө авах шаардлага, түүнчлэн Хорооны санал, зөвлөмжийн талаарх тухайн оролцогч улсын байр суурь, саналыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага, сан, хөтөлбөр болон бусад эрх бүхий байгууллагуудад хүргүүлнэ.

2. Түүнчлэн Хороо нь холбогдох оролцогч улсын зөвшөөрөлтэйгээр Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхүүдийг хэрэгжүүлэхэд бодит ахиц гаргахад нь оролцогч улсуудад дэмжлэг үзүүлэхүйц олон улсын арга хэмжээний талаар тус тусын салбарт эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргахад нь тухайн байгууллагуудад туслалцаа үзүүлэх ач холбогдол болж энэхүү Протоколын дагуу өргөдөлтэй холбогдон гарах аливаа асуудлаар дээрхи байгууллагуудад мөн хандаж болно.

3. Пактад тусгагдсан эрхийн хэрэгжилтийг сайжруулж, оролцогч улсуудад мэргэжилтний болон техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор энэхүү Протоколтой холбогдуулан эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хүрээнд үндэстний чадавхи бий болгоход хувь нэмэр оруулахын тулд холбогдох оролцогч улсын зөвшөөрөлтэйгээр Нэгдсэн Үндэстний



Байгууллагын санхүүгийн журам, зохицуулалтын дагуу ажиллах Итгэлцлийн санг Ерөнхий Ассамблейн холбогдох журмын дагуу байгуулна.

4. Энэхүү зүйлийн заалтууд нь оролцогч улс бүр Пактаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь саад учруулахгүй.

15 дугаар зүйл
Жилийн илтгэл

Хороо нь жилийн илтгэлдээ энэхүү Протоколын дагуу хийсэн ажлын ерөнхий тоймыг тусгана.

16 дугаар зүйл
Түгээн таниулах ба мэдээлэх

Оролцогч улс бүр Пакт болон энэхүү Протоколыг өргөнөөр сурталчилж, түгээн таниулахын хамт Хорооны санал, зөвлөмж, тухайлбал тухайн оролцогч улстай холбогдсон асуудлын талаарх мэдээллийг хүртээлтэй болгоход тус дөхөм үзүүлэх, түүнчлэн уг мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй хэлбэрээр гаргах үүрэг хүлээнэ.

17 дугаар зүйл
Гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн орох

1. Пактад гарын үсэг зурсан, түүнийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон аливаа улс энэхүү Протоколд гарын үсэг зурахад нээлттэй.

2. Пактыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон аль ч улс энэхүү Протоколыг соёрхон батална. Соёрхон баталсан тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Пактыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон аливаа улс энэхүү Протоколд нэгдэн ороход нээлттэй байна.

4. Нэгдэн орсон тухай баримт бичгээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар нэгдэн орсонд тооцно.

18 дугаар зүйл
Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү Протокол нь түүнийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон арав дахь баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын



Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш 3 сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Соёрхон баталсан буюу нэгдэн орсон арав дахь баримт бичгийг хадгалуулснаас хойш энэхүү Протоколыг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон улсын хувьд Протокол нь соёрхон баталсан болон нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш 3 сарын дараа хүчин төгөлдөр болно.

19 дүгээр зүйл Нэмэлт, өөрчлөлт

1. Аль ч оролцогч улс энэхүү Протоколд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал гаргаж, түүнийгээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг оролцогч улсуудад уламжилж, уг саналыг хэлэлцэж шийдвэрлэх зорилгоор оролцогч улсуудын бага хурал хуралдуулах эсэхээ мэдэгдэхийг хүснэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 4 сарын дотор оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй хувь нь бага хурал хуралдуулахыг дэмжвэл Ерөнхий нарийн бичгийн дарга уг бага хурлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор хуралдуулна. Ерөнхий нарийн бичгийн дарга уг бага хуралд оролцсон хийгээд саналаа өгсөн оролцогч улсын гуравны хоёр хувь буюу олонхийн саналаар дэмжигдсэн аливаа нэмэлт, өөрчлөлтийг батлуулахаар Ерөнхий Ассамблейд өргөн барих бөгөөд дараа нь нийт оролцогч улсуудад хүргүүлнэ.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу дэмжигдэж, батлагдсан нэмэлт, өөрчлөлт нь уг нэмэлт, өөрчлөлтийг анх батлахад байлцсан оролцогч улсуудын гуравны хоёр нь түүнийг хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ хадгалуулснаас хойшхи 30 дахь өдөр хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш тэрхүү нэмэлт, өөрчлөлт нь аливаа оролцогч улсын хувьд уг нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ хадгалуулснаас хойшхи 30 дахь өдөр хүчин төгөлдөр болно. Нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улс заавал дагаж мөрдөнө.

20 дугаар зүйл Цуцлах

1. Оролцогч аливаа улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар энэхүү Протоколыг хэдийд ч цуцалж болно. Уг мэдэгдлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан өдрөөс хойш 6 сарын дараа Протокол тухайн улсын хувьд хүчингүй болно.

2. Цуцлалт хүчин төгөлдөр болохоос өмнө 2 болон 10 дугаар



зүйлийн дагуу гаргасан аливаа өргөдлийн хувьд энэхүү Протоколын заалтыг үргэлжлүүлэн мөрдөх буюу 11 дүгээр зүйлийн дагуу эхэлсэн аливаа хянан шалгах ажиллагааг хэрэгжүүлэхэд саад болохгүй байна.

21 дүгээр зүйл **Ерөнхий нарийн бичгийн даргын мэдэгдэл**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Пактын 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүх улсад дараах мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:

(a) Энэхүү Протоколд гарын үсэг зурсан, соёрхон баталсан, нэгдэн орсон тухай;

(b) Энэхүү Протокол болон түүнд 19 дүгээр зүйлийн дагуу оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон тухай; болон

(c) 20 дугаар зүйлийн дагуу хийсэн аливаа цуцлалт.

22 дугаар зүйл **Албан ёсны хэл**

1. Энэхүү Протоколын араб, хятад, англи, франц, орос, испани хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын архивт хадгална.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Протоколын баталгаат хуулбарыг 26 дугаар зүйлд заасан бүх улсад хүргүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 09 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 203

Улаанбаатар
хот

Бурхан халдуны тухай

Хан Хэнтийн нурууны Бурхан халдун уул бол Монголчуудын их түүх, Эзэн Чингисийн намтар цадигт холбогдолтой үйл явдлууд өрнөж байсан түүхэн газар нутаг, байгалийн унаган төрхөөрөө байгаа үзэсгэлэнт сайхан хайрхан билээ.

Бурхан халдун хайрханы байгалийн унаган төрх, Монголын түүх, соёлын дурсгалыг хадгалан хамгаалах зорилгоор эрдэмтэн судлаачид,



иргэд, байгууллагаас гаргаж буй саналыг дэмжиж, Үндсэн хуулийн гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Уламжлалт ёс заншлаа дээдлэн Бурхан халдун хайрханы тахилгын ёслолыг "Дээд овоо"-ны бэлд шинээр бий болгосон овоонд үйлдэж байхаар тогтоосугай.

2. Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн газар нутгийн байгалийн болон соёлын хосгүй гайхамшигт үнэ цэнийг тодорхойлж дэлхийн өвд бүртгүүлэх санал боловсруулан, ЮНЕСКО-д хандах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т чиглэл болгосугай.

3. Чингис хааны намтар түүхтэй холбоотой түүх, соёлын өвийг судалж тогтоох, хадгалж хамгаалах, дэлхий дахинаа сурталчлан алдаршуулах зорилгоор өргөн хүрээтэй, үр дүнтэй ажил зохион байгуулахыг төрийн болон төрийн бус байгууллага, шинжлэх ухаан, түүх соёлын зүтгэлтнүүд, нийт ард иргэдэд уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 164

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн 17 дугаар хавсралт, Иргэний нисэхийн тухай хуулийн 6.1.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2007 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 175 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр"-т дор дурдсан агуулгатай дараахь нэмэлт оруулсугай:

а) 1.5 дахь заалтад 1.5.47-1.5.50 дахь дэд заалт:



"1.5.47. "ачаа, тээвэр зуучийн байгууллага" гэж агаарын тээвэрлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр нисэхийн аюулгүй байдлын үүрэг хүлээсэн байгууллагаас тавьсан шаардлагын дагуу агаараар ачаа, шууданг тээвэрлэх, түүний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагыг;

1.5.48. "аюулгүй байдлын үзлэг шалгалт" гэж эрх бүхий байгууллагаас нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага болон бусад байгууллага Үндэсний хөтөлбөрт заасан аюулгүй байдлын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих үйл ажиллагааг;

1.5.49. "аюулгүй байдлын хяналт" гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, хориглосон болон сэжигтэй эд зүйлийг нисэх буудал, агаарын хөлөгт нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг;

1.5.50. "үнэмлэхжүүлэлт" гэж нисэхийн аюулгүй байдлын үүрэг хүлээсэн байгууллагаас тухайн этгээд зохих түвшинд өөрийн үүргийг гүйцэтгэх чадвартайг үнэлж, албан ёсоор баталгаажуулах үйл ажиллагааг."

б) 4 дэх заалтад 4.2.10, 4.7.4 дэх дэд заалт:

"4.2.10. агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, хориглосон болон сэжигтэй эд зүйлийг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам боловсруулах.

4.7.4. аюулгүй байдлын үзлэгээр зорчигчоос зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, эд зүйл илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу аюулгүй болгох арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд зорчигчийг саатуулах зорилгоор үзлэгийн цэг дээр цагдаагийн байнгын ажилтан томилж ажиллуулах."

в) 6 дахь заалтад 6.19 дэх дэд заалт:

"6.19. Нисэх буудлын хориотой бүсэд байгаа агаарын хөлөгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавина."

г) 7 дахь заалтад 7.9, 7.10 дахь дэд заалт:

"7.9. Агаарын тээвэрлэгч нь зорчигч агаарын хөлгөөс буухдаа эд зүйлээ орхиогүй болохыг шалгаж, баталгаажуулах үүрэгтэй.

7.10. Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлөгт үзлэг, шалгалт хийсний дараа зөвшөөрөлгүй этгээд агаарын хөлөгт нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үүрэгтэй."

д) 8 дахь заалтад 8.24 дэх дэд заалт:

"8.24. Агаарын тээвэрлэгч нь хэв журам зөрчсөн зорчигчид авах аюулгүй байдлын арга хэмжээ, хэв журам зөрчсөн зорчигчийг тээвэрлэх журмыг өөрийн аюулгүй байдлын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлнэ."

е) 14 дэх заалтад 14.10, 14.11 дэх дэд заалт:

"14.10. Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлөг хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн талаархи тагнуулын байгууллагын мэдээ, мэдээллийн дагуу агаарын хөлөгт нуусан зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис болон аюултай эд зүйлийг илрүүлэх зорилгоор үзлэг, шалгалт хийх үүрэгтэй.

14.11. Хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлөг Монгол Улсын нутаг дэвсгэрт газардсан тохиолдолд тухайн агаарын хөлөг цаашид аяллаа үргэлжлүүлэх хүртэлх хугацаанд хууль хяналт болон онцгой байдлын байгууллага, холбогдох бусад байгууллага хөлгийн зорчигч болон нисэх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авна."

ж) 15 дахь заалтад 15.9 дэх дэд заалт:

"15.9. Ерөнхий газар нь нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага болон тухайн нисэх буудалд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага Үндэсний хөтөлбөрт заасан аюулгүй байдлын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тодорхой давтамжтай хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ."

2. Мөн хөтөлбөрийн 8.22 дахь дэд заалтын "Аюулгүй байдал" гэсний өмнө "Зохих журмын дагуу аюулгүй байдлын үзлэг хийлгэсэн зорчигч, тэдгээрийн гар тээшийг агаарын хөлөгт нэвтрүүлэх хүртэл хяналт тавина." гэж нэмсүгэй.

3. Мөн хөтөлбөрийн дараахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

а) 6 дахь заалтын 6.3 дахь дэд заалт:

"6.3. Нисэх буудлын хориотой бүсийг Ерөнхий газар тогтооно."

б) 9 дэх заалтын 9.10 дахь дэд заалт:

"9.10. Тээшийг агаарын хөлөгт ачихаас өмнө тээш ялгах талбай, эсхүл нисэх буудлын тээш хадгалах газарт байрлуулах бөгөөд тээш ялгах талбайд зөвхөн зөвшөөрөл бүхий этгээдийг нэвтрүүлнэ. Зөвшөөрөлгүй этгээд нэвтэрсэн тохиолдолд тээшийг агаарын хөлөгт ачихаас өмнө аюулгүй байдлын үзлэгт дахин оруулна."

в) 14 дэх заалтын 14.4, 14.7 дахь дэд заалт:

"14.4. Нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан тохиолдолд тухайн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг гүйцэтгэж байгаа байгууллага холбогдох мэдээллийг цуглуулж, нислэгийн маршрутын дагуу байгаа болон дайран өнгөрч болзошгүй нислэгийн мэдээллийн бүсийг хариуцаж байгаа нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад энэ талаар нэн даруй мэдэгдэнэ. Энэ тохиолдолд тухайн агаарын хөлөг газардах магадлалтай нисэх буудал нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авсан байна."

14.7. Хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлгийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр газардахыг зөвшөөрч болно. Энэ тохиолдолд хууль хяналт болон онцгой байдлын байгууллага, холбогдох бусад байгууллага газардсан агаарын хөлгийг нисгэхгүй байх бүхий л арга хэмжээг авна."

г) 15 дахь заалтын 15.4, 15.5, 15.8 дахь дэд заалт:

"15.4. Ерөнхий газар нь Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд аюулгүй байдлын аудит, үзлэг шалгалт, судалгаа хийх журам боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд энэхүү үүргийг гүйцэтгэх зохих сургалтад хамрагдсан боловсон хүчинтэй байна."

15.5. Ерөнхий газар нь нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллага болон нислэгийн хоол, хүнс бэлтгэх байгууллагын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд жилд нэгээс доошгүй удаа үзлэг шалгалт хийн тайлан гаргаж, илэрсэн дутагдлыг цаг алдалгүй арилгах арга хэмжээ авна."

15.8. Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдэлтэй холбогдох хэсэгчилсэн дасгал, сургуулилтыг жилд нэгээс доошгүй удаа, бүрэн хэмжээний дасгал, сургуулилтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна."

4. Мөн хөтөлбөрийн 3.1 дэх заалтын "Агаарын хөлөгт гарсан гэмт халдлага болон зарим онцгой хэргийн тухай" 1963 оны Токиогийн конвенци гэснийг "Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай" 1963 оны Токиогийн конвенци гэж, "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авахтай тэмцэх тухай" 1970 оны Гаагийн конвенци гэснийг "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай" 1970 оны Гаагийн конвенци гэж, "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдэл гаргуулахгүй байх тухай" 1971 оны Монреалийн конвенци гэснийг "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай" 1971 оны Монреалийн конвенци гэж, "Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор тэмдэглэл хийх тухай" 1999 оны Монреалийн конвенци гэснийг "Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор тэмдэг тавих тухай" 1991 оны Монреалийн конвенци гэж, "Олон улсын иргэний нисэхэд үйлчилж буй нисэх буудалд хүчирхийллийн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай" 1999 оны Монреалийн протокол гэснийг "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай" Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн конвенцийн "Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай" 1988 оны Монреалийн нэмэлт протокол гэж тус тус өөрчилсүгэй.

5. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, биелэлтэд нь хяналт тавьж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын аюулгүй байдлын аудитын бэлтгэл ажлыг тодорхой төлөвлөгөөний дагуу хангахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Х.БАТТУЛГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар
хот

**Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх
тэргүүлэх чиглэл, цөм технологийн
жагсаалт батлах тухай**

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6.1.2-ыг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. "Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт"-ыг хэвсралт ёсоор баталсугай.

2. Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун)-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2010 оны 173 дугаар
тогтоолын хэвсралт

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ /2010-2014 ОН/**

1. Хүний хөгжил, амьдралын чанар
2. Байгалийн нөөцийг хамгаалах, ашиглах
3. Хөдөө аж ахуйг эрчимжүүлэх
4. Өндөр технологи, мэдээллийн технологи нэвтрүүлэх

Тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх цөм
технологийн жагсаалт

**"Хүний хөгжил, амьдралын чанар" тэргүүлэх чиглэлийн
хүрээнд:**

1. Хүний хөгжил, төлөвшил, боловсролын шинэчлэлийн технологи,
2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний оношилгоо, эмчилгээний технологи, биотехнологи.

**"Байгалийн нөөцийг хамгаалах, ашиглах" тэргүүлэх
чиглэлийн хүрээнд:**

1. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгаль орчны бохирдол, газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх технологи.
2. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, цөлжилтийг сааруулах, дасан зохицох технологи.
3. Усны нөөцийг хамгаалах, ашиглах технологи.
4. Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний үр ашиг, хэмнэлтийн технологи.
5. Сэргээгдэх эх үүсвэр бүхий эрчим хүчний технологи.
6. Эрдэс баялгийн хайгуул, олборлолт, боловсруулалтын

технологи.

7. Нүүрс, нефть боловсруулах технологи.
8. Барилгын материал үйлдвэрлэлийн технологи.

"Хөдөө аж ахуйг эрчимжүүлэх" тэргүүлэх чиглэлийн

хүрээнд:

1. Мал, амьтныг эрүүлжүүлэх, ашиг шимийг нь нэмэгдүүлэх технологи.
2. Үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамлын шилмэл сорт гаргах, тариалах, үйлдвэрлэх технологи;
3. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи.

"Өндөр технологи, мэдээллийн технологи нэвтрүүлэх"

тэргүүлэх чиглэлийн хүрээнд:

1. Нанотехнологи, биотехнологи.
2. Мэдээлэл, микропроцессор, программ хангамж, цахим үйлчилгээний технологи.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар
хот

Шинжлэх ухааны салбарыг дэмжих зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Шинжлэх ухаан, технологийн салбарын менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.
2. Шинжлэх ухаан, технологийн салбарын менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл болон улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун нарт тус тус даалгасугай.
3. "Шинжлэх ухаан, технологийн салбарын менежментийн шинэчлэл-хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг зохион байгуулж дүнг жил бүрийн IY улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Б.Энхтүвшин нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С. БАТБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ё. ОТГОНБАЯР

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН МЕНЕЖМЕНТИЙН
ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Авах арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах байгууллага
Нэг. Үйл ажиллагааны уялдааг хангах					
1	Шинжлэх ухаан, технологийн салбарын удирдлагын бүх түвшинд арга барилыг шинэчилж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох	Шинжлэх ухааны академийн гишүүдийг сонгох тогтолцоог шинэчлэх, залуу эрдэмтдийн квот бий болгох	Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийн менежментэд шинэчлэлт гарч, удирдлага, үйл ажиллагаанд оролцох залуучуудын оролцоо нэмэгдэнэ	2010-2012	ШУА
		Шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох	Шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа нээлттэй, ил тод болж, бүтээлч, идэвхтэй үйл ажиллагаа бэхжинэ	2010-2013	БСШУЯ
		Судалгаа, боловсруулалтын ажлын явц, үр дүнгийн үзүүлэлтийг шинэчилж, хяналт болон хариуцлагын тогтолцоог тодорхой болгох	Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааны эцсийн үр дүн сайжирч, хяналт болон хариуцлагын тогтолцоо тодорхой болно	2010-2013	БСШУЯ

<p>2</p> <p>Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, зорилттой уялдуулан салбар дундын тулгамдсан, томоохон асуудлыг шийдвэрлэх төсөл хэрэгжүүлэх</p>	<p>Салбар дундын тулгамдсан, томоохон асуудлыг шийдвэрлэх төсөл хэрэгжүүлж, үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах</p>	<p>2010 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яамтай, 2011 онд Зам, тээвэр, Барилга, хот байгуулалтын яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай, 2012 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамтай тус тус хамтран төсөл хэрэгжүүлнэ</p>	<p>2010-2012</p>	<p>БСШУЯ</p>
	<p>Боловсруулсан технологи, бүтээгдэхүүнийг эрэлтэд нийцүүлэн бодит хэрэглээ болгох тогтолцоог боловсронгуй болгох</p>	<p>Төр, хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилт бүхий сан байгуулж, инновацийн төсөл хэрэгжүүлж, инновацийн грант олгоно. Эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, бизнесийн байгууллагын түншлэлийг өргөжүүлнэ</p>	<p>2010-2013</p>	<p>БСШУЯ ШУА</p>

<p>БСШУЯ ШУА</p>	<p>2010- 2012</p>	<p>Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн судалгааны ажлын үйлдвэр сайжирч, суурь болон хэвсэргэ судалгааны ажилд бодитой ахиц гарна</p>	<p>Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн судалгааны ажлын үйлдвэр сайжруулан томоохон зорилготой ажилд чиглүүлэх</p>	<p>Техник, технологи, хөдөө аж ахуй, анагаах ухаан, нийгмийн ухааны эрдэм шинжилгээний байгууллагуудыг судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нэгдэл болгон бүтээж, зохион байгуулалтыг шинэчлэх</p>
<p>БСШУЯ ШУА</p>	<p>2010-2012</p>	<p>Биевэлдэгийн болон малын дайвар бүтээгдэхүүн гүн боловсруулах үйлдвэр байгуулж, чанараа өндөргүй, хадгалалт сайтай тээвэрлээр улсын нөөцийн 30 хувийг хангана. Эрүүл мэндийн салбарт шинэ технологи нэвтрүүлж, улсын эм болдмалгийн хэрэгцээний 50-иас доошгүй хувийг дотооддоо үйлдвэрлэх болно. Техник, технологийн салбарт, тухайлбал дулаалгын материал, хүнсний бүтээгдэхүүний технологи, эрчим хүчний хэмжээтэй технологийн чиглэлээр инновацийн бүтэц бий болгоно</p>	<p>Шинжлэх ухаан, технологийн үйлдвэрлэл-бизнесийн харилцан уялдаатай үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх</p>	
<p>БСШУЯ ШУА</p>	<p>2013- 2015</p>	<p>Экспортын болон импортыг орлуулах бүтээгдэхүүн, тэдгээрийн үйлдвэрлэл нэмэгдэнэ</p>	<p>Шинжлэх ухааны салбарт хувийн хэвшил болон гадаад оронтой хамтран шинжлэх ухааны парк, инкубатор байгуулах</p>	

4	Салбар дундын нэгдсэн, төрөлжсөн лаборатори байгуулан, жил бүр хөрөнгө оруулалтаар иеубаторыг дэмжих.	Судалгаа, үйлдвэрлэлийн нэгдлийн үйл ажиллагааг хөрөнгө оруулалтаар дэмжих.	Судалгааны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор жилд 1 тэрбумаас доошгүй төгрөг зарцуулна.	2010-2012	БСШУЯ СЯ
Хоёр, Санхүүжилтийг боловсронгуй болгох.					
5	Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийг үйл ажиллагааны үр дүнтэй нь урсдуулах, санхүүжилтийн хуваарилалтыг шинэчлэн тогтоох.	Шинжлэх ухаан, технологийн салбарт төсвөөс олгох санхүүжилтийн 1/3-ийг суурь судалгаанд, 2/3-ыг хэрэглээний судалгаанд зарцуулах.	Хэрэглээний судалгаанд бодит ахиц гарна.	2010-2012	БСШУЯ СЯ
				2010-2012	БСШУЯ СЯ
			Хүрээлэнгүүдийн ажлын бодит үр дүнг дүгнэх боломж бүрдэнэ.		



6	<p>Шинжлэх ухаан, технологийн салбарт олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоо бий болгох</p>	<p>Эрдэм шинжилгээний байгууллагын орлого олох боломжийг нэмэгдүүлэх</p>	<p>Эрдэм шинжилгээний байгууллага бие даан үйл ажиллагаа явуулах боломж нэмэгдэж, өөрийн үйл ажиллагаанаасаа орлого олдог болно</p>	2011-2012	БШУЯ
7	<p>Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тогтоож, шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх</p>	<p>Засгийн газраас хэрэгжүүлж байгаа шинэчлэлийн бодлого, зорилттой уялдуулан захиалгат шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зардлыг жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусгах</p>	<p>Шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломж нэмэгдэнэ</p>	2011-2012	БШУЯ СЯ
		<p>Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэрэгжүүлэхэд зориулан жилд улсын төсвөөс 1.2 тэрбумаас доошгүй төгрөг зарцуулна</p>		2011-2013	БШУЯ

Гурав. Эрдэмтдийг дэмжих, залгамж халааг бэлтгэх

	БСШУЯ ШУА	БСШУЯ
8	Эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль хамтран шинжлэх ухааны нэрийн мэргэшлийн эрдэмтэн, судлаачдыг бэлтгэх	2011-2012
	Эрдэмтэн бэлтгэх үйл ажиллагаанд чанарын ахиц гарна	2010-2012
	Эрдэмийн зэрэг хамгаалуулах шаардлагыг өндөржүүлэн, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх	Жилд 20-иос доошгүй залуу докторт судалгааны грант олгох
9	Шинжлэх ухааны зарим чиглэлээр шилдэг залуу судлаачдад докторын дараахь судалгааны ажлын грант олгодог болох	Докторын дараахь грант олгох журам боловсруулж хэрэгжүүлэх

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2010 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 177

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Концессын тухай хуулийн 11.4-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Концесс олгох уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичиг, уралдаант шалгаруулалтын саналыг үнэлэх журмыг батлан мөрдүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2010 оны 177 дугаар
тогтоолын хавсралт

**КОНЦЕСС ОЛГОХ УРАЛДААНТ
ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Концессын тухай хуулийн 11.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтын аргаар концессоор олгоход энэхүү журмыг баримтална.

1.2. Хуулийн дагуу батлагдсан концессын зүйлийн жагсаалтыг үндэслэн концесс олгох уралдаант шалгаруулалтыг төрийн өөрийн өмчийн



хувьд Төрийн өмчийн хороо, орон нутгийн өөрийн өмчийн хувьд тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга (цаашид "эрх бүхий этгээд" гэх) хариуцаж зохион байгуулан хэрэгжүүлнэ.

1.3. Концессын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд концессыг зөвхөн уралдаант шалгаруулалтыг зохион байгуулж, төсөл сонгон шалгаруулсны үндсэн дээр олгоно.

1.4. Эрх бүхий этгээд нь батлагдсан концессын зүйлийн жагсаалтыг нийтэд мэдээлэх, уралдаант шалгаруулалтын хуваарь болон баримт бичгийг батлах, баримт бичгийн үнийг тогтоох, уралдаант шалгаруулалтыг зарлаж түүнд оролцогчдын жагсаалтыг батална.

1.5. Эрх бүхий этгээд нь концессын гэрээний төслийг төрийн өөрийн өмчийн хувьд Засгийн газарт, орон нутгийн өөрийн өмчийн хувьд тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "Уралдаант шалгаруулалт" гэж Концессын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу концесс эзэмших эрх авах этгээдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг;

2.1.2. "Уралдаант шалгаруулалтын комисс" гэж Концессын тухай хуулийн 13.10-т заасан ажлын хэсгийг;

2.1.3. "Уралдаант шалгаруулалтын хуваарь" гэж эрх бүхий этгээдээс баталсан уралдаант шалгаруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг;

2.1.4. "Уралдаант шалгаруулалтын зар мэдээ" гэж Концессын тухай хуулийн 12.2-т заасны дагуу нийтэд зарласан мэдээллийг;

2.1.5. "Оролцох хүсэлт" гэж уралдаант шалгаруулалтын зарын дагуу урьдчилсан шалгаруулалтад оролцохоор Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдлээс ирүүлсэн холбогдох албан бичгийн иж бүрдлийг;

2.1.6. "Урьдчилсан шалгаруулалтын баримт бичиг" гэж Концессын тухай хуулийн 13.3, 13.4-т заасан шалгуур үзүүлэлтүүд.



шаардлагатай бусад мэдээллийг тусгасан баримт бичгийг;

2.1.7. "Оролцох санал" гэж оролцох хүсэлт гаргасан этгээдээс урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн дагуу ирүүлсэн саналыг;

2.1.8. "Оролцогч" гэж урьдчилсан шалгаруулалтаар сонгогдсон этгээдийг;

2.1.9. "Уралдаант шалгаруулалтын баримт бичиг" гэж оролцогчдод олгох Концессын тухай хуулийн 13.7-д заасан мэдээлэл, шаардлагатай бусад мэдээллийг тусгасан баримт бичгийг;

2.1.10. "Төслийн санал" гэж оролцогчоос уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дагуу ирүүлсэн саналыг;

2.1.11. "Баримт бичгийн үнэ" гэж урьдчилсан шалгаруулалтын болон уралдаант шалгаруулалтын баримт бичгийг хэвлэн олшруулах, түгээх өртгийг.

Гурав. Уралдаант шалгаруулалтын комисс,
түүний ажлын зохион байгуулалт

3.1. Эрх бүхий этгээд нь уралдаант шалгаруулалтын комиссыг (цаашид "комисс" гэх) Концессын тухай хуулийн 13.10-т заасны дагуу холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулна.

3.2. Комисс нь сондгой тооны 5-9 хүний бүрэлдэхүүнтэй байна. Комисс нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

3.3. Комиссын дарга, нарийн бичгийн дарга нь эрх бүхий этгээдийн ажилтан байна. Уралдаант шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нь хуралдаанд таслах эрхтэй оролцоно.

3.4. Комиссын гишүүн нь төслийн саналыг үнэлэх чадвартай, тухайн салбарт мэргэшсэн, сүүлийн 3 жилийн хугацаанд уралдаант шалгаруулалтад оролцогчтой хөдөлмөрийн гэрээний харилцаанд ороогүй ажилтан байна. Комиссын гишүүн нь "Гишүүний мэдүүлэг"-ийг энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу эрх бүхий этгээдэд бичгээр мэдэгдсэнээр гишүүний эрх нь хүчин төгөлдөр болно.

3.5. Комиссын бүрэн эрх:

3.5.1. урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг

батлан оролцох хүсэлт гаргасан этгээдэд олгох;

3.5.2. урьдчилсан шалгаруултад оролцох саналыг нээх;

3.5.3. урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг үнэлж уралдаант шалгаруулалтын оролцогчийг сонгох, оролцогчдын жагсаалт гаргах;

3.5.4. уралдаант шалгаруулалтын баримт бичгийг оролцогчид олгох;

3.5.5. шаардлагатай тохиолдолд оролцогчидтой уулзалт зохион байгуулах;

3.5.6. уралдаант шалгаруулалтын төслийн саналыг нээх;

3.5.7. уралдаант шалгаруулалтад оролцогчийн ирүүлсэн төслийн саналд үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд тодруулга авах, оролцогчтой хэлэлцээ хийх;

3.5.8. оролцогчдын дарааллуулсан жагсаалт гаргах;

3.5.9. жагсаалтын дарааллыг баримтлан концессын гэрээний нөхцөлийн талаар оролцогчтой хэлэлцээ хийж үнэлгээний дүгнэлтийг эрх бүхий этгээдэд хүргүүлэх.

3.5.10. эрх бүхий этгээд нь гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохирсон оролцогчтой концессын гэрээг байгуулснаар комиссын бүрэн эрх дуусгавар болно.

3.6. Комиссын даргын бүрэн эрх:

3.6.1. комиссын хуралдааныг удирдах, бусад ажлыг зохион байгуулах;

3.6.2. уралдаант шалгаруулалтын хуваарьт заасан ажлын явцын талаар эрх бүхий этгээдэд тухай бүр мэдээлэл өгөх, тайлагнах;

3.6.3. уралдаант шалгаруулалтын хуваарь, оролцогчдын жагсаалт, уралдаант шалгаруулалтын баримт бичиг, үнэлгээний дүгнэлтийг эрх бүхий этгээдэд танилцуулж, шийдвэр гаргуулах.

3.7. Комиссын нарийн бичгийн даргын бүрэн эрх:

3.7.1. комиссын хуралдааны бэлтгэл ажлыг хангах,



хуралдааны товыг зарлах, комиссын дарга, гишүүдийг холбогдох мэдээллээр хангах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, холбогдох баримт бичгийг бүрдүүлэх, хавтаст хэрэг хөтлөх, баримтжуулж хадгалах;

3.7.2. уралдаант шалгаруулалттай холбоотой зарыг нийтэд мэдээлэх, шалгаруулалтад оролцох болон төслийн саналыг хүлээн авч, комиссын шийдвэрийн дагуу уралдаант шалгаруулалтад оролцогчид баримт бичиг олгох, санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

3.7.3. урьдчилсан болон уралдаант шалгаруулалт явуулсан тухай тайлан бичих;

3.7.4. уралдаант шалгаруулалтын хавтаст хэргийг зохих журмын дагуу архивт шилжүүлэх.

3.8. Комиссын гишүүний бүрэн эрх:

3.8.1. үнэлгээ хийхэд шаардлагатай хууль тогтоомж, дүрэм, заавар, журмыг судалсан байх;

3.8.2. урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулахад оролцох;

3.8.3. саналыг урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгасан үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлэх;

3.8.4. комиссын шийдвэр гарахад өөрийн саналыг хараат бусаар өгч оролцох;

3.8.5. комиссын хуралдааны шийдвэрт гарын үсэг зурах.

3.9. Комиссын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Комиссын хуралдаан гишүүдийн гуравны хоёр ирснээр хүчин төгөлдөрт тооцогдоно. Комисс асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Комиссын нэг гишүүн нэг саналын эрхтэй байна.

3.10. Комиссын шийдвэрт хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Эсрэг саналтай гишүүн энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна.

3.11. Комисс нь хэлэлцээний үр дүнд гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон оролцогчтой концессын гэрээ байгуулах



эрх олгох тухай, эсхүл уралдаант шалгаруулалтыг хүчингүй болгох тухай шийдвэрийг (цаашид "үнэлгээний дүгнэлт" гэх) эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

3.12. Үнэлгээний дүгнэлтэд комиссын хуралдааны шийдвэртэй холбоотой баримт бичиг (хуралдааны тэмдэглэл, концессын гэрээ байгуулах эрх олгох тухай, эсхүл уралдаант шалгаруулалтыг хүчингүй болгох тухай шийдвэр, үнэлгээний тайлан)-ийг хавсаргана.

3.13. Үнэлгээний дүгнэлтийг хууль тогтоомж, уралдаант шалгаруулалтын баримт бичигтэй нийцээгүй, эсхүл тэдгээрийг зөрчсөн гэж эрх бүхий этгээд тогтоосон бол үнэлгээний дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор энэхүү зөрчлийг арилгах тухай шаардлагыг комисст албан бичгээр мэдэгдэнэ. Энэхүү шаардлагад үндэслэл, тайлбараа заавал дурдсан байна.

3.14. Комисс нь эрх бүхий этгээдээс албан бичиг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хуралдаж энэхүү журмын 3.13-т заасан шаардлагад дурдсан алдаа, зөрчил үндэслэлтэй эсэхийг хэлэлцэн үнэлгээний дүгнэлт гаргана.

Дөрөв. Комиссын үйл ажиллагаанд тавих хяналт

4.1. Эрх бүхий этгээд нь комиссын үйл ажиллагаанд дараахь байдлаар хяналт тавина:

4.1.1. комиссын үнэлгээний дүгнэлтийг хянан баталгаажуулах;

4.1.2. уралдаант шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой оролцогчоос ирүүлсэн гомдол, маргааныг хянан шийдвэрлэх;

4.1.3. комиссын гишүүн хууль зөрчсөн тохиолдолд түүнийг өөрчлөх;

4.1.4. комиссын гишүүн нь ашиг сонирхлын зөрчил үүссэн тул гишүүнээс өөрөө татгалзсан тохиолдолд комиссын гишүүнийг нөхөн томилох.

4.2. Эрх бүхий этгээд комиссын гишүүнд тодорхой хэмжээний хөдөлмөрийн хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож болно.

4.3. Уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай нарийн мэргэжлийн зөвлөгөө өгөх дотоодын болон

гадаадын шинжээч, зөвлөх, мэргэжлийн багийг эрх бүхий этгээд өөрийн санаачилгаар буюу комиссын хүсэлтээр томилон ажиллуулж болно.

Тав. Уралдаант шалгаруулалтын дараалал

5.1. Уралдаант шалгаруулалтын хуваарийг боловсруулах, батлах:

5.1.1. комисс уралдаант шалгаруулалтын хуваарийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу боловсруулж, эрх бүхий этгээдээр батлуулна;

5.1.2. эрх бүхий этгээд нь шаардлагатай бол уралдаант шалгаруулалтын хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.2. Урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, батлах:

5.2.1. комисс урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг урьдчилсан шалгаруулалтын жишиг баримт бичгийн дагуу боловсруулан батална;

5.2.2. комисс нь оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд оролцох санал хүлээн авах эцсийн хугацааг нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс хойш 10-аас доошгүй хоногоор сунгана;

5.2.3. комисс урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг бүх хүсэлт гаргагчид нэгэн зэрэг мэдэгдэнэ.

5.3. Уралдаант шалгаруулалтын зар мэдээг нийтлэх, сурталчлах:

5.3.1. зар мэдээнд Концессын тухай хуулийн 12.1, 12.2-т заасны дагуу холбогдох мэдээллийг тусгасан байна;

5.3.2. уралдаант шалгаруулалтад олон оролцогч оролцуулах, нээлттэй өрсөлдөөнийг өрнүүлэх зорилгоор дотоод, гадаадын бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдыг уулзалт, ярилцлаганд урих, бусад хэлбэрийн сурталчилгааг зохион байгуулж болно.

5.4. Урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлт хүлээн авах, урьдчилсан шалгаруулалтын баримт бичиг олгох:



5.4.1. оролцох хүсэлтийг уралдаант шалгаруулалтын зар мэдээг нийтэд мэдээлснээс хойш оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө хүлээн авна;

5.4.2. оролцох хүсэлтийг илэрхийлсэн албан бичгийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид зохих журмын дагуу олгосон итгэмжлэл, урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн үнэ төлсөн баримтын хамт ирүүлнэ;

5.4.3. оролцох хүсэлт ирүүлсэн Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, тэдгээрийн нэгдэлд урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг олгоно.

5.5. Уралдаант шалгаруулалтад оролцох санал хүлээн авах:

5.5.1. оролцох хүсэлт гаргасан этгээд нь урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт заасан санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө оролцох саналаа битүүмжилж ирүүлнэ;

5.5.2. оролцох хүсэлт гаргасан этгээд ирүүлсэн саналдаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө шинээр санал ирүүлж, өмнө ирүүлсэн саналаа буцаан авна;

5.5.3. хугацаа хоцорч ирсэн, эсхүл урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн саналыг хүлээж авахгүйгээр шууд хаягаар нь буцаана;

5.5.4. оролцох хүсэлт гаргасан этгээдийн саналыг комиссын нарийн бичгийн дарга бүртгэн хүлээж авна;

5.5.5. оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанд багтаж ирсэн боловч бүртгэж амжаагүй саналыг санал хүлээн авах эцсийн хугацаагаар бүртгэнэ.

5.6. Оролцох саналыг нээх, оролцогчийг сонгон шалгаруулах:

5.6.1. урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан этгээд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд ирүүлсэн саналыг нээх үед байлцах эрхтэй;

5.6.2. саналыг урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт заасан хаяг бүхий газарт төвлөсөн хугацаанд нээнэ. Саналын эх хувийг бүртгэсэн дарааллаар нээж урьдчилсан шалгаруулалтын баримт

бичигт заасны дагуу мэдээлэл хийнэ;

5.6.3. саналыг нээх үед тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд комиссын гишүүд болон саналыг нээхэд байлцсан бусад этгээд гарын үсэг зурна. Урьдчилсан шалгаруулалтад оролцогч гарын үсгээ зурахгүй байх нь урьдчилсан шалгаруулалтын тэмдэглэл хүчингүй болох үндэслэл болохгүй;

5.6.4. санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө саналаа буцааж авах хүсэлтээ ирүүлсэн, эсхүл санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн оролцох саналаас бусад аль ч саналаас татгалзахгүй;

5.6.5. оролцох саналыг уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журмын дагуу үнэлж, урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан оролцогчдоор хязгаарлан жагсаалт гаргана.

5.6.6. Концессын тухай хуулийн 13.5-д заасны дагуу концессын зүйлийн онцлогоос шалтгаалан оролцогчдын жагсаалтыг урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтүүдийг хамгийн сайн хангасан тодорхой тооны оролцогчдоор хязгаарлах саналаа эрх бүхий этгээдэд тавьж болно.

5.7. Уралдаант шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, батлуулах:

5.7.1. концессын зүйлийн төрөл, салбарын онцлогоос шалтгаалан техник, эдийн засгийн үндэслэл, санхүүжилтийн нөхцөл, шаардлага, шалгуур үзүүлэлтийг уралдаант шалгаруулалтын баримт бичигт нарийвчлан тусгах боломжгүй гэж эрх бүхий этгээд үзвэл оролцогчдоос тусгайлан санал хүлээн авах, эцэслэн боловсруулах гэсэн хоёр шаттайгаар уралдаант шалгаруулалтын баримт бичгийг боловсруулна;

5.7.2. хоёр шаттайгаар уралдаант шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахдаа комисс Концессын тухай хуулийн 13.7-д заасны дагуу тусгайлан санал авна;

5.7.3. комисс уралдаант шалгаруулалтын баримт бичгийг уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичгийн дагуу боловсруулж, эрх бүхий этгээдээр батлуулна.

5.8. Оролцогчдод уралдаант шалгаруулалтын баримт бичиг олгох, төслийн санал хүлээн авах:



5.8.1. комисс оролцогчид уралдаант шалгаруулалтын баримт бичгийн үнэ төлснийг нотлох баримтыг үндэслэн баримт бичгийг олгоно;

5.8.2. эрх бүхий этгээд өөрийн санаачилгаар, эсхүл оролцогч төслийн саналаа ирүүлэхээс өмнө эрх бүхий этгээдэд хүсэлт тавьсан тохиолдолд уулзалт хийх, ажлын талбайтай танилцах, тодруулга өгөх ажлыг зохион байгуулж болно. Энэхүү арга хэмжээг уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу хэрэгжүүлнэ;

5.8.3. эрх бүхий этгээд төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө уралдаант шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд төслийн санал хүлээн авах эцсийн хугацааг нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс хойш 20-иос доошгүй хоногоор сунгана;

5.8.4. эрх бүхий этгээд уралдаант шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг бүх оролцогчид нэгэн зэрэг мэдэгдэнэ;

5.8.5. уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу оролцогч нь саналаа төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө битүүмжлэл бүхий техникийн болон санхүүгийн санал хэлбэрээр ирүүлнэ;

5.8.6. ирүүлсэн саналд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд оролцогч санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө шинээр санал ирүүлж, өмнө ирүүлсэн саналаа буцаан авна;

5.8.7. хугацаа хоцорч ирсэн, эсхүл уралдаант шалгаруулалтын баримт бичигт зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн төслийн саналыг хүлээж авахгүйгээр хаягаар нь шууд буцаана;

5.8.8. төслийн саналыг комиссын нарийн бичгийн дарга уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу бүртгэж хүлээн авна;

5.8.9. төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанд багтаж ирсэн боловч бүртгэж амжаагүй саналыг санал хүлээн авах эцсийн хугацаагаар бүртгэнэ.

5.9. Төслийн саналыг нээх:

5.9.1. уралдаант шалгаруулалтад оролцогч, түүний



итгэмжлэгдсэн төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд төслийн саналыг нээх үед байлцах эрхтэй;

5.9.2. төслийн саналыг уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан хаяг бүхий газарт, товлосон хугацаанд нээнэ. Техникийн саналыг бүртгэгдсэн дарааллаар нээж, уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу мэдээлэл хийнэ;

5.9.3. төслийн саналыг нээх үед тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд комиссын гишүүд болон саналыг нээхэд байлцсан бусад этгээд гарын үсэг зурна. Оролцогч гарын үсгээ зурахгүй байх нь уралдаант шалгаруулалтын тэмдэглэл хүчингүй болох үндэслэл болохгүй;

5.9.4. төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө саналаа буцааж авах хүсэлтээ ирүүлсэн, эсхүл санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн төслийн саналаас бусад аль ч саналаас татгалзахгүй.

5.10. Төслийн саналыг үнэлэх:

5.10.1. техникийн саналын үнэлгээг уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журмын дагуу үнэлнэ;

5.10.2. комисс техникийн саналыг үнэлж дуусган, оролцогчдод уралдаант шалгаруулалтад цаашид оролцохоор шалгарсан эсэх тухай болон санхүүгийн саналыг нээхээр товлосон газар, хугацааг мэдэгдэнэ;

5.10.3. техникийн санал нь тэнцээгүй оролцогчийн санхүүгийн саналыг нээхгүй буцаана;

5.10.4. оролцогчийн санхүүгийн саналыг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг нь байлцуулан товлосон газар, хугацаанд нээнэ;

5.10.5. комисс санхүүгийн саналыг уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журмын дагуу үнэлж, шалгарсан оролцогчийн жагсаалт гаргана.

5.11. Гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийх:

5.11.1. комисс шалгарсан оролцогчийн жагсаалтын дагуу



Концессын тухай хуулийн 15.1, 15.2-ыг үндэслэн концессын гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийнэ;

5.11.2. хэлэлцээний дүнд гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохирсон нэг оролцогчтой байгуулах концессын гэрээний төсөл, үнэлгээний дүгнэлтийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

Зургаа. Бусад

6.1. Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Концессын тухай хуулийн 19.4-т заасны дагуу концессын гэрээ байгуулахыг дэмжээгүй бол хэлэлцээг дахин хийх эсэх, эсхүл уралдаант шалгаруулалтыг дахин явуулах эсэх шийдвэрийн аль нэгийг гаргана.

6.2. Эрх бүхий этгээд нь Концессын тухай хуулийн 17.1.3-т заасны дагуу уралдаант шалгаруулалт зарласан боловч санал ирээгүй, эсхүл шаардлагад нийцсэн санал ирээгүй, уралдаант шалгаруулалтыг дахин зарласан ч төвлөсөн хугацаанд санал ирэх магадлал бага гэж үзсэн тохиолдолд шууд гэрээ байгуулах саналыг Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ;

6.3. Концессын тухай хуулийн 6.2.6-д заасны дагуу Төрийн өмчийн хороо улсын хэмжээнд концессын талаархи нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлнэ;

6.4. Төрийн өмчийн хороо нь улсын хэмжээнд концесс олгох уралдаант шалгаруулалтын хуваарь, зар мэдээ, бусад шаардлагатай гэж үзсэн мэдээллийг цахим хуудсанд байршуулна;

6.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийг концессын гэрээгээр олгох уралдаант шалгаруулалттай холбоотой болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн өмчийн хороонд тухай бүр гарган өгч, мэдээллийн санд бүртгүүлж байна.

Долоо. Маргааныг шийдвэрлэх

7.1. Хүсэлт гаргагч болон оролцогч нь уралдаант шалгаруулалттай холбоотой гомдлыг Концессын тухай хуулийн 34.1-д заасны дагуу эрх бүхий этгээдэд гаргана. Шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй.



Журмын 1 дүгээр хавсралт

**УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН КОМИССЫН
ГИШҮҮНИЙ МЭДҮҮЛЭГ**

.....би

(комиссын гишүүний нэр, албан тушаал)

Концессын тухай хуулийн 13.10-т заасны дагуу
эрх бүхий этгээдийн дугаар тушаал, захирамжаар байгуулагдсан
комиссын бүрэлдэхүүнд гишүүнээр томилогдон ажиллахыг зөвшөөрч,
энэхүү мэдүүлгээр уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахдаа
ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлж, дараахь зүйлийг
баримталж ажиллахаа баталж байна:

1. Комиссын гишүүний хувьд хүлээсэн үүргээ үнэнч, шударгаар
гүйцэтгэж эрх бүхий этгээдийн ашиг сонирхлыг дээдэлнэ.

2. Комиссын хуралдаанд оролцох, шийдвэр гаргахдаа өөрийн
саналыг хараат бусаар өгнө.

3. Уралдаант шалгаруулалттай холбоотой бичиг баримтыг
гуравдагч этгээдэд задруулахгүй.

4. Комиссын гишүүний эрх, гишүүний хувьд олж авсан нууц
мэдээллийг буруугаар ашиглахгүй.

5. Уралдаант шалгаруулалтад оролцогчийн эрх тэгш байдлыг
хангах, түүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал,
байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл
бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахгүй.

6. Уралдаант шалгаруулалтад оролцогч, бусад аливаа этгээдээс
авлига авахгүй.

7. Уралдаант шалгаруулалтын үнэлгээнд нөлөө үзүүлэх аливаа
оролдлого, саналын талаар комиссын дарга буюу эрх бүхий этгээдэд
тухай бүр мэдэгдэнэ.

8. Уралдаант шалгаруулалтад оролцогч талуудтай сонирхлын
зөрчилгүй, хэрэв сонирхлын зөрчил бий болох нөхцөл үүссэн тохиолдолд
мэдэгдэж, үнэлгээний хорооны гишүүнээс татгалзана.

Гарын үсэг:

Огноо:

Албан ажлын хэрэгцээнд:

	Овог, нэр	Албан тушаал	Гарын үсэг	Огноо	Цаг, минут
Хүлээн авсан					
Хүлээлгэн өгсөн					

УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТЫН ХУВААРЬ

Агуулга	Огноо эсхүл эцсийн хугацаа
Урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, батлах	[огноо]
Уралдаант шалгаруулалтыг зарлах	[огноо] ¹
Оролцох хүсэлт хүлээн авах	[огноо] ²
Урьдчилсан шалгаруулалтын баримт бичиг олгох	[огноо]
Оролцох саналыг хүлээн авах	[огноо] цагаас өмнө
Оролцох саналыг нээх, үнэлэх	[огноо] цаг
Оролцогчдын жагсаалт гарган тэнцсэн оролцогчид мэдэгдэл хургуулэх	[огноо]
Тусгайлан санал авах баримт бичгийг боловсруулах*	[огноо]
Тусгайлан санал авах баримт бичгийг олгох*	[огноо]
Тусгайлан санал авах*	[огноо]
Уралдаант шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах, эцэслэн боловсруулах	[огноо]
Уралдаант шалгаруулалтын баримт бичиг олгох	[огноо]
Шаардлагатай тохиолдолд тэнцсэн оролцогчидтой уулзалт, ажлын талбайтай танилцах, тодруулга өгөх ажлыг зохион байгуулах	[огноо]
Төслийн санал хүлээн авах	[огноо] цагаас өмнө
Техникийн саналыг нээх	[огноо] цаг
Техникийн саналыг үнэлэх, хэлэлцээ хийх	[огноо]
Техникийн саналын үнэлгээний үр дүнг мэдэгдэх	[огноо]
Санхүүгийн саналыг нээх	[огноо] цаг
Санхүүгийн саналыг үнэлэх, хэлэлцээ хийх	[огноо]
Шалгарсан оролцогчдын жагсаалт гаргах	[огноо]
Шалгарсан оролцогчдын жагсаалтын дагуу концессын гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийх	[огноо]
Үнэлгээний дүгнэлт, концессын гэрээний төслийг эрх бүхий байгууллагад хургуулж шийдвэрлүүлэх	[огноо]
Эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл олгосноор шалгарсан оролцогчтой концессын гэрээнд гарын үсэг зурах	[огноо]

¹ *Тус журмын 5.7.1-д заасны дагуу хоёр шаттайгаар уралдаант шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах тохиолдолд

² [огноо]1 болон [огноо]2 хооронд Концессын тухай хуулийн 12.4-т заасны дагуу хоёр сараас доошгүй хугацаа байна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 180

Улаанбаатар
хот

Ой тэмдэглэх тухай

“Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Ерөнхийлөгчийн 2008 оны 399 дүгээр зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.
2. Ойд бэлтгэх, тэмдэглэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлж, дүнг тухай бүр Засгийн газарт танилцуулахыг зохион байгуулах хороо (М.Энхболд)-нд даалгасугай.
3. Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2011 оны улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД

Засгийн газрын 2010 оны 180 дугаар
тогтоолын хавсралт

**ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХУВЬСГАЛЫН 100 ЖИЛИЙН
ОЙД БЭЛТГЭХ, ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга -Монгол Улсын Шадар сайд М.Энхболд

Гишүүд: -Гадаад харилцааны сайд Г.Занданшатар;
-Сангийн сайд С.Баярцогт;
-Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж;
-Батлан хамгаалахын сайд Л.Болд;
-Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд
Е.Отгонбаяр;



- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Д.Баттулга /зөвшилцсөнөөр/;
- Архивын ерөнхий газрын дарга Д.Өлзийбаатар;
- Засгийн газрын Хэвлэл, мэдээллийн албаны дарга М.Оюунчимэг;
- Төрийн ёслолын албаны дарга А.Батсайхан;
- Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Б.Энхтүвшин;
- Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн захирал С.Чулуун.

Нарийн бичгийн дарга -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Нямжав

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 184

Улаанбаатар
хот

Зам, тээвэр, барилга, нийтийн аж ахуйн салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай:

а) цаг агаарын хүндрэлтэй үед улсын чанартай авто зам, замын байгууламжид эвдрэл гарч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулах явдлаас урьдчилан сэргийлэх, авто тээврийн хэрэгсэл саадгүй нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор авто замын засвар, арчлалтын ажлын чанарыг сайжруулан тогтмолжуулах, ургац хураалтын тээвэрт ашиглагдах зам, гүүрийн шинэчлэлт, засварын ажлыг яаралтай эхлүүлэн чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэх, гэнэтийн эвдрэлийг шуурхай засварлаж байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

б) нийтийн тээврийн хэрэгсэл, хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн гараашийн засвар, дулаалгыг хугацаанд нь чанартай хийж, сэлбэг хэрэгсэл болон өвлийн улирлын шатахуун, тослох материалыг зохих хэмжээнд нь нөөцөлж, иргэдэд найдвартай үйлчлэх нөхцөл бүрдүүлэх;



в) дулааны цахилгаан станц, нийтийн тээврийн аж ахуйн нэгж, байгууллагын түлээ, нүүрс нөөцлөх, түлш, шатахуун татан авах тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллах;

г) иргэний нисэхийн салбар /нисэх онгоцны буудал, харьяа албад/-ын өвөлжилтийн бэлтгэл болон нислэгийн аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

д) төв, суурин газрын барилга байгууламж, орон сууцны цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний ээлжит засвар, үйлчилгээ, угаалга, туршилтыг төлөвлөсөн хугацаанд нь хийж дуусгах талаар холбогдох арга хэмжээ авах.

2. Орон нутгийн тээврийн болон барилга, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагын өвлийн бэлтгэлийг хангуулж, түлээ, нүүрс нөөцлөх, түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл татан авах ажлыг зохион байгуулах, төв суурин газрын барилга байгууламж, орон сууцны цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний ээлжит засвар, үйлчилгээ, угаалга, туршилт, авто замын засвар арчлалтыг төлөвлөсөн хугацаанд нь хийж дуусгах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Х.БАТТУЛГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 187

Улаанбаатар
хот

Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг 2010 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дор дурдсанаар тогтоосугай:

№	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр)		
		Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ)		Дизелийн түлш
		90 хүртэл	90 болон түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхонгор, Бичигт, Хавирга	0.000	0.000	0.000
2	Ханх, Ульханмайхан	0.000	0.000	0.000
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав, Алтанбулаг	220.000	220.000	215.000

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны зарим бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай" Засгийн газрын 2010 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 87 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 188

Улаанбаатар
хот

**Түлш, эрчим хүчний салбарын 2010-2011 оны
өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Түлш, эрчим хүчний салбарын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд үндсэн болон туслах тоноглолын их засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, нүүрс нөөцлөх ажлыг төлөвлөсөн хугацаанд нь зохион байгуулан явц, үр дүнг сар бүр Засгийн



газарт танилцуулж байхыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо /Д.Сугар/-нд даалгасугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтад заасан эрчим хүчний зарим үйлдвэр, компанид олгох шаардлагатай байгаа татаасын тооцоог хянан Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

3. 2010-2011 оны өвлийн их ачааллын үед дулааны цахилгаан станцуудад түлэх нүүрсний 20-иос доошгүй хоногийн нөөцийг бүрдүүлэх зорилгоор нүүрс тээвэрлэх вагоноор тасралтгүй, найдвартай хангах арга хэмжээ авч, тээвэрлэлтийн график, төлөвлөгөө гарган ажиллахыг Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.

4. Төвлөрсөн дулаан хангамжтай зарим аймгийн төвийн дулааны станцын 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажил удаашралтай байгааг анхааралдаа авч, их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалт, нүүрс нөөцлөх ажлыг хугацаанд нь чанартай хийж дуусгахыг Увс, Ховд, Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Аймгийн төв, сумдын эрчим хүчний үйлдвэрийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулж нүүрс нөөцлөх, түлш, шатахуун татан авах ажлыг зохион байгуулан өөрийн нутаг дэвсгэр дээр байгаа цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, дулааны шугам, аваарийн болон сумдын дизель станцын засварыг графикт хугацаанд нь чанартай хийж дуусгахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ

Засгийн газрын 2010 оны 188 дугаар
тогтоолын хавсралт

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭР, КОМПАНИД ШААРДЛАГАТАЙ
БАЙГАА ТАТААСЫН ХЭМЖЭЭ**

№	Үйлдвэрүүд	2010 онд батлагдсан /сая.төг/	2011 онд шаардагдах /сая.төг/
1	Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэр	6,132.0	9,237.9
	Говь-Алтай аймгийн эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй сумдын дизель түлшний үнэ /15 сум, 2 төсгөн/	647.0	865.6



2	Завхан аймгийн эрчим хүчний үйлдвэр	5,240.0	8,480.0
	Завхан аймгийн эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй сумдын дизель түлшний үнэ /18 сум/	653.0	966.4
3	"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ХК	1,200.0	1,600.0
4	"Баруун бүсийн эрчим хүчний систем" ХК	4,000.0	5,715.9
5	"Даланзадгадын дулааны цахилгаан станц" ХК	1,800.0	1,800.0
6	"Налайхын дулааны станц" ХК	900.0	960.0
7	"Багануурын дулааны станц" ХК	900.0	900.0
8	"Дулаан Шарьен гол" ХК	-	537.6
Нийт дүн		21,472.0	31,063.4

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 72 ДУГААР ЗҮЙЛИЙГ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд Шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн /цаашид хуулийн гэх/ 72 дугаар зүйлийн 72.1-д заасан **"гэмт хэрэг үйлдсэнээс хойш"** гэдгийг тухайн гэмт хэргийг үйлдэж дууссан өдрийн 24 цаг өнгөрмөгц гэж ойлгоно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 96 дугаар зүйлийн 96.2-т **"Хугацааг тоолоход уг хугацаа эхэлсэн цаг, хоногийг тооцоонд оруулахгүй"** гэж заасныг үндэслэн хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхлэнэ.

Тухайлбал, 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн 19 цагт хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг 2005 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 00 цагаас эхлэн тоолох ба уг хугацаа 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн 24 цагт дуусгавар болно.



Цаг хугацааг тоолохдоо Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 96 дугаар зүйлийг баримтлана.

1.1. Гэмт үйлдэл хийх, уг хэргийн улмаас хор уршиг буй болох хоёр үргэлж нэгэн зэрэг байдаггүй тул хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн гэмт хэрэг үйлдэж дууссан үеэс эхлэн тоолно.

Хөөн хэлэлцэх хугацааг зөв тоолохын тулд гэмт хэрэг үйлдсэн он, сар, өдөр, цагийг нарийвчлан тогтоосон байвал зохино.

1.2. Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн тохиолдолд хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан нөхцлийг бүрдүүлсэн эсхүл гэмт үйлдэл таслан зогсоогдсон үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно.

Харин гэмт хэрэг үйлдэхээр завдсан тохиолдолд гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхгүйг санаатай хийсэн эсхүл бүрэн хийсэн гэж тухайн этгээд ойлгосон тэр үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолж тодорхойлно.

1.3. Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд хуульд заасан хамгийн хүнд ялтай гэмт хэргийг үйлдэж дууссан үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно.

Үргэлжилсэн болон давтан үйлдэлтэй гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хамгийн сүүлчийн үйлдэл төгссөн үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолж тодорхойлно.

Удааширсан үйлдэлтэй гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт үйлдлээ хийж дуусгасан өдрөөр эсхүл тухайн үйлдэл таслан зогсоогдсон үеэс эхлэн тоолно.

2. Хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д заасан “**эрүүгийн хариуцлагад татаж болохгүй**” гэдэгт шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан байцаан шийтгэх ажиллагааны (эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх г.м) алиныг ч явуулахгүй байхыг ойлгоно.

3. Эрүүгийн хариуцлагад татах хугацаанд гэмт хэрэг гарсан өдрөөс эхлэн шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаа хамаарах тул хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол уг нөхцөл шалтгаан илэрч тогтоогдсон шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасныг үндэслэн



шийдвэрлэнэ.

3.1. Шүүх хэргийг хүлээн авсны дараа хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон бол яллагдагчийг шүүхэд шилжүүлээгүй тохиолдолд шүүгчийн захирамжаар, яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн үед анхан шатны шүүх хуралдаанаас шүүгч захирамж, шүүх тогтоол гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгоно.

3.2. Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хэрэг хянагдаж байх үед хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд тухайн шатны шүүх хуралдаанаас хэргийг хэрэгсэхгүй болгосон магадлал, тогтоол гаргана.

3.3. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэм буруугийн асуудлаар маргавал шүүх хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

Шүүх хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэх явцад шүүгдэгч гэм буруугүй болох нь тогтоогдвол зөвхөн энэхүү үндэслэлээр л хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Харин шүүгдэгч гэм буруутай болох нь нотлогдвол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох боловч ял оногдуулахгүйгээр, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэнэ.

4. Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхдөө уг хугацаа тасарсан эсхүл зогссон эсэхийг анхаарвал зохино.

4.1. Гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрөөгүй байхад шинээр гэмт хэрэг санаатай үйлдсэн бол хөөн хэлэлцэх хугацаа тасрах бөгөөд энэ тохиолдолд өмнөх хэргийн хөөн хэлэлцэх хугацааг сүүлчийн хамгийн хүнд ялтай гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн шинээр тоолно.

4.2. Гэмт хэрэг болгоомжгүйгээр үйлдсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасрахгүй бөгөөд энэ тохиолдолд хоёр хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зэрэгцэж үргэлжлэн тоологдоно.

4.3. Тухайн этгээд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт болон шүүхээс оргон зайлсан тохиолдолд байцаан шийтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн эрх бүхий албан тушаалтны шийдвэр гарсан үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа зогсоно.



Оргон зайлсан этгээд баривчлагдсан буюу өөрөө сайн дураараа буцаж ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээх ба өмнө нь тоологдож байсан хугацааг оруулан тоолно.

4.4. Таслан сэргийлэх арга хэмжээ авагдаагүй этгээд оршин суугаа газраасаа өөр тийш явсныг оргон зайлсан гэж үзэхгүй бөгөөд энэ тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа зогсохгүй.

5. Хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т заасан зохицуулалт нь зөвхөн шүүхийн бүрэн эрхэд хамааралтай тул мөрдөн байцаах ажиллагааг ердийн журмаар явуулж хэргийг шүүхэд шилжүүлэх ба хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

5.1. Хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх нь зүйтэй гэж шүүх үзвэл шүүгдэгч гэм буруутай эсэхийг тогтоосны дараа хэргийг хэрэгсэхгүй болгоно.

5.2. Харин шүүх хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх боломжгүй гэж үзвэл шүүгдэгч гэм буруутай болон түүнд ял оногдуулах эсэх асуудлыг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

Энэ тохиолдолд шүүх хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т заасны дагуу гэм буруутай этгээдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй.

6. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2391 дүгээр тогтоолоор 1968 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталж, 1970 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон "Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай конвенц"-д Монгол Улс 1969 онд нэгдэн орсон бөгөөд хуулийн 72 дугаар зүйлийн 72.5-д үүнийг зохицуулсан тул мөн хуулийн 30 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

С.НЯМЖАВ

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 3

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэн,
Утас 329487